


Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны
гарын авлагын 3 дугаар хэсэрэлт



БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО ISO 22001:2018

ОЮУТНЫ СУРАЛЦАХУЙ ҮЙЛ ЯВЦЫН УРСГАЛ ДИАГРАММ

БАЙГУУЛЛАГЫН НЭР	Монгол улсын их сургууль (МУИС)
БАЙГУУЛЛАГЫН ХАЯГ	Их сургуулийн гудамж – 1, Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот
БАРИМТ БИЧГИЙН №	NUM/EOMS/PFC/016
ХУВИЛБАР №	01
БОЛОВСРУУЛСАН ОГНОО:	2025-10-01

НЭГ.ЗОРИЛГО

Их сургуулийн оюутны сурлагын гүйцэтгэлийг хянаж, аливаа тусгай хэрэгцээг хангах боломж бүрдүүлэх замаар оюутны суралцах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

ХОЁР.ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү журам нь МУИС-ийн оюутнуудын суралцах үйл ажиллагаанд хамаарна.

ГУРАВ.ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Сургалтын алба, оюутны алба, тэнхимийн эрхлэгч нар уг журмыг мөрдөх, хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

ДӨРӨВ.ҮЙЛ ЯВЦЫН УРСГАЛ ДИАГРАММ

4.1. Холбогдох нэгж нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1. Хичээл сонголтод зөвлөх

4.1.2. Оюутны гүйцэтгэлийн мониторинг

4.1.3. Тусгай хэрэгцээт оюутанд туслах, мониторинг

ТАВ.ОЮУТНЫ СУРГАЛТЫН ҮЙЛ ЯВЦЫН ХАНДЛАГА

№	Үе шат	Норматив эшлэл	хариуцагч
Оюутны гүйцэтгэлийн мониторинг			
1	Тэнхимүүд оюутны гүйцэтгэлийг даалгавар өгч шалгах, ирц бүртгэх, дотоод үнэлгээ өгөх гэх мэт аргаар тогтмол мониторинг хийнэ.		
2	Сургалтын хяналт-шинжилгээ, үнэлгээний алба оюутны гүйцэтгэл, хэрэгцээ, хүлээлттэй танилцах зорилгоор тэнхимүүдтэй хамтран оюутнуудтай уулзалт зохион байгуулна: 3, 4 жилийн хөтөлбөрөөр суралцагсадтай 2 дахь жилээс, 1 жилийн хөтөлбөрөөр суралцагсадтай эхний жил уулзана.	Уулзалтын тэмдэглэл - УТ	Оюутны албаны дарга
3	Ирц хангалтгүй, сул дүнтэй, даалгавраа цаг тухайд нь ирүүлдэггүй зэрэг гүйцэтгэл доогуур оюутныг онцгойлон анхаарч мониторинг хийнэ. Тэдэнтэй тусдаа уулзалт зохион байгуулж, уулзалтын тэмдэглэл хөтөлнө.	УТ	Оюутны албаны дарга
4	Ийм онцгой тохиолдолд тохирсон үйл ажиллагаа төлөвлөж, түүний дагуу тогтмол хяналт тавьж ажиллана.	үйл ажиллагааны төлөвлөгөө, мониторингийн бүртгэл	Оюутны албаны дарга
5	Оюутны гүйцэтгэл, сурлагын хэрэгжилтийг Хөтөлбөрийн алба хянаж, аудит хийнэ. Аудитын тайланг Сургалтын хяналт-шинжилгээ, үнэлгээний албанд хүргүүлж, хянан шийдвэрлэнэ.	Сурлагын аудитын тайлан	Хөтөлбөрийн алба
6	Сургалтын хяналт-шинжилгээ, үнэлгээний алба аудитын дүгнэлтийг хэлэлцэж, дүгнэлт тус бүрээр арга хэмжээ төлөвлөнө. Төлөвлөсөн үйл ажиллагаа бүрийг дуустал хянаж байх ёстой.	Сургалтын аудитын дүнгээр хэрэгжүүлэх ажлын бүртгэл	Оюутны албаны дарга
Тусгай хэрэгцээт оюутны мониторинг			
1	Сул дүн авдаг эсвэл ихэнх жирийн оюутантай ойролцоо байх чадваргүй оюутнуудыг дээр	Тусгай хэрэгцээт оюутны нэрс	Оюутны албаны дарга

	дурдсанчлан тогтмол уулзах, сургалтын гүйцэтгэлийн аудит хийх замаар тогтооно. Сэтгэцийн асуудалтай оюутнуудыг мөн уулзалтын үеэр болон бусад тохирох аргаар илрүүлнэ.		
2	Сэтгэцийн асуудалтай оюутнуудад их сургуулиас томилсон зөвлөхүүд зөвлөгөө өгч, хяналт тавина. Бүтэн цагийн нэг зөвлөх, хагас цагийн гурван зөвлөхийг томилно.	Зөвлөгөөний бүртгэл	зөвлөх
3	Энэ мэт тусгай шаардлага тулгарвал үүнийг баримтжуулж, захирлаас тусгай зөвшөөрөл авна.	Оюутны нэрс	Оюутны албаны дарга
Мэргэжил/ Хичээл сонголтод туслах			
1	Тэнхим бүр оюутнуудад түгээмэл болон нарийн мэргэжлийн талаар дэлгэрэнгүй ойлголт өгөх үүднээс ажил мэргэжлийн үзэсгэлэнг зохион байгуулдаг.		
2	Тэнхимийн зөвлөх, ганцаарчилсан зөвлөхтэй оюутны уулзалт ярилцлага зохион байгуулна.		
3	Уулзалтын үеэр оюутнуудын санал, хүсэлтийг баримтжуулна. Давтагдсан хүсэлт, асуулгад дүн шинжилгээ хийж, тохирох хариултыг бэлтгэнэ.	FAQ	Оюутны албаны дарга

ЗУРГАА.ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Энэ үйл явцад холбоотой эрсдэлийг тодорхойлж, баримтжуулан Эрсдэл ба боломжийн бүртгэлд тусгасан болно.

ДОЛОО.ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ (KPIs)

№	ГТҮ-ийн тодорхойлолт

НАЙМ.ОРОЛТ/ГАРАЛТЫН МАТРИЦ

.... - оролт	Оролт	Үйл явц	Гаралт	Гаралтын холболт

ЕС.НОРМАТИВ ЭШЛЭЛ

№	Баримтын нэр	Баримтын No.
1	Сурлагын аудитын тайлан	
2	Үйл ажиллагааны төлөвлөгөө,	

АРАВ.БҮРТГЭЛИЙН ЖАГСААЛТ

№	Маягтын нэр	Маягтын No.
1	Уулзалтын тэмдэглэл	NUM/EOMS/FMT/50
2	Үйл ажиллагааны мониторингийн бүртгэл	NUM/EOMS/FMT/51
3	Сургалтын аудитын тайлан	NUM/EOMS/FMT/52
4	Сургалтын аудитын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний мониторингийн бүртгэл	NUM/EOMS/FMT/53

5	Тусгай хэрэгцээт оюутны нэр	NUM/EOMS/FMT/54
6	Зөвлөгөө өгсөн бүртгэл	NUM/EOMS/FMT/55
7	FAQ – мэргэжил сонголт	NUM/EOMS/FMT/56

АРВАН НЭГ ХЯНАЛТЫН ТҮҮХ, ЗӨВШӨӨРӨЛ

Хувилбар №	Өөрчлөлт	Хянасан огноо	Өөрчлөлтийн шалтгаан	Өөрчлөлт хийсэн	Өөрчлөлтийг баталсан
00	Эх хувь	xx.xx.xx	---	---	----